

Комплаенсийн үйл ажиллагааны тайлан



Тайлант хугацаа: 2024 оны эхний хагас жил

Агуулга


Комплаенсийн үүрэг



Комплаенсийн эрсдэл



Комплаенсийн байнгын сайжруулалт



Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх



Комплаенс хариуцсан нэгж жил бүрийн эхэнд тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-ын дэргэдэх хороонд танилцуулж батлуулдаг билээ. Бид төлөвлөгөөний дагуу 2024 оны эхний хагас жилд компанийн комплаенсийн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж хууль, журмын нийцлийг хангуулах, комплаенсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх санал зөвлөмж хүргүүлэх, комплаенсийн соёлыг бэхжүүлэх ач холбогдлыг таниулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүллээ. Мөн Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, журмын шаардлагыг ханган ажиллалаа. Түүнчлэн ISO 37301:2021 стандартын магадлах 1 аудитыг баталгаажуулалтын Монсертф ХХК-аар хийлгэж гэрчилгээг амжилттай баталгаажууллаа.

Комплаенсийн үүрэг

Хууль, журмын нийцлийг хангах



Үүрэг даалгаврын хэрэгжилт орхигдохгүй байх



Оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих



А. Заавал дагаж мөрдөх үүрэг

Монгол улсын хууль, төрийн эрх бүхий байгууллагын баталсан дүрэм, журам, тогтоол, тушаал, шийдвэр

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд хамраалтай хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хөрөнгийн бирж, Татварын Ерөнхий Газар болон бусад төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад 27 төрлийн тайлан мэдээг давтагдсан тоогоор 80 удаа хүргүүлж, тайлагнасан.

Б. Дагаж мөрдөх үүрэг

Компанийн дотоод дүрэм, журам, дотоод хороод болон Гүйтцэтгэх захирлын тушаал, ТЗК-ийн тогтоол

Компанийн дотоод дагаж мөрдөх үүргийн хэрэгжилтэд үүрэг даалгавар системээр дамжуулан тогтмол хяналт тавьж, сар бүр удирдлагуудад тайлагнадаг бөгөөд комплаенсийн эрсдэл үүсч болзошгүй тохиолдолд санал, зөвлөмж бэлтгэн хүргүүлж газар, нэгжүүдтэйгээ хамтран ажилладаг.

Гэрээний дагуу хүлээсэн үүрэг

Олон Улсын зах зээлд гаргасан Хулан бонд: 2024.01.18-ны өдөр “Deutsche Bank AG” болон “Korea Investment & Securities Asia Limited” компанитай хамтран 225,000,000 ам.долларын “Хулан” бондыг олон улсын зах зээл дээр арилжаалах ажлыг амжилттай гүйцэтгэлээ. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Хөрөнгө оруулагчдад Үйл ажиллагааны тайлан болон бусад мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлсэн.

Ипотекийн зээлээр баталгаажсан бонд: Тайлант хугацаанд ипотекийн зээлээр баталгаажсан бондын төлбөрүүдийг цаг хугацаанд нь төлж, хэлцэл эрхлэн гүйцэтгэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн холбогдох тайлан мэдээг зохих хугацаанд хүргүүлэн ажилласан.

ОУ-ын стандарт

Дараах Олон улсын ISO стандартуудын шаардлагыг хангаж, үйл ажиллагаандаа нийцүүлэн хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулсан:

- ISO 27201:2013 Мэдээллийн аюулгүй байдал;
- ISO 31000:2015 Эрсдэлийн удирдлага;
- ISO 37301:2021 Комплаенсийн удирдлагын стандарт.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээсэн үүрэг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод хөтөлбөрийг дэмжин МИК нэг сая мод тарих амлалт өгсөн билээ. Үүнээс 5200 гаруй мод тарьсан ба цаашид ч жил бүр төлөвлөөний дагуу модоо тарьж арчлан ургуулж цөлжилтийг бууруулах, усны ундаргыг нэмэгдүүлэх үйлсэд хувь нэмэрээ оруулсаар байх болно. Мөн зохиолч Б.Сайнжаргалын “Бизнесийн байгууллагын санхүү эдийн засгийн шинжилгээ /2024/” номоор МУИС-ийн Бизнесийн сургуулийн номын фондыг нэмэгдүүлэх, Монгол улсад банкны салбар үүсэж бэхэжсэний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээнд хамтран ажиллах зэргээр санхүүгийн салбарын цаашдын хөгжилд хувь нэмэрээ оруулсаар байна.

Комплаенсийн эрсдэл

Эрсдэлийн хамгаалалт



Бизнесийн үр ашиг өсөх



Ил тод байдлыг нэмэгдүүлэх



Комплаенсийн нэгж нь жил бүрийн эхэнд газар нэгжүүдтэй хамтран гадагшаа хүлээсэн комплаенсийн үүргийг тодорхойлж түүнийг хэрэгжүүлээгүйн улмаас компанид учирч болзошгүй эрсдэлийг хагас жил тутамд үнэлж, тогтмол хянадаг. Комплаенсийн эрсдэл дунд болон өндөр үнэлэгдсэн үүргийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ төлөвлөн санал, зөвлөмж хүргүүлж хамтран ажилладаг.

Тайлант хугацаанд компани нийт 113 комплаенсийн үүргийг тодорхойлсон ба түүнийг биелүүлээгүйгээс үүсэх аливаа санхүүгийн, үйл ажиллагааны болон нэр хүндийн эрсдэл үүсээгүй мөн харилцагч нараас гомдол санал ирүүлээгүй байна. Компани бүхий л үйл ажиллагаандаа бизнесийн ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн ажилладаг бөгөөд ажилтнуудын зүгээс ёс зүйн аливаа зөрчил гаргасан тохиолдол байхгүй.

Комплаенсийн байнгын сайжруулалт

Хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх



Ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх



Ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэх



Сургалт, хөгжил:

Комплаенсийн нэгж нь жил бүрийн эхэнд Комплаенсийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж Хүний нөөцийн удирдлагын хэлтэстэй хамтран нийт ажилтнуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хариуцлагатай, ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт, мэдээллээр тогтмол ханган ажилладаг ба мэдлэг бататгах тест авч сургалтын хөтөлбөрийг сайжруулах дээр анхаарч ажилладаг. Тайлант хугацаанд шинэ ажилтнуудад улирал бүр, нийт ажилтнуудад хагас жил бүр танхимын сургалтыг зохион байгуулдаг мөн цахим цуврал сургалт, мэдээллийг сар бүр тогтмол хүргүүлж комплаенсийн соёлыг төлөвшүүлж, комплаенсийн эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж хамтран ажилласан.

Тайлагнал:

Комплаенсийн үүргийн хэрэгжилтийн хяналтыг тогтмол хэрэгжүүлж сар бүрийн 10-ны дотор Удирдлагын хороонд, комплаенсийн үйл ажиллагааг хараат бус бие даасан байдлаар хэрэгжүүлдгийн хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын хороонд хагас жил бүр болон комплаенсийн чиг үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой санал зөвлөмжийг тухай бүр холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн.

Хяналтын программ /Үүрэг даалгавар/:

Комплаенсийн үүргийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих зорилгоор хяналтын программ болох “Үүрэг даалгавар”-ыг дотооддоо хөгжүүлсэн бөгөөд программыг ашигласнаар үүргийн бүртгэлийг автоматжуулах, нэгдсэн бүртгэлтэй болох удирдлагыг шаардлагатай мэдээллээр түргэн шуурхай хангах зэрэгт ач холбогдолтой байдаг. Комплаенсийн нэгжээс программыг сайжруулахтай холбоотой үйл ажиллагааг Мэдээлэл технологийн газартай хамтран хэрэгжүүлдэг мөн хэрэглэгч нарыг гарын авлага зөвлөмжөөр ханган ажилладаг.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

Хамтын ажиллагааг тэлэх



Хөрөнгө оруулалт татах
боломжийг нэмэгдүүлэх




Харилцан итгэлцлийг бий
болгох



Монгол улсын Мөнгө Угаах Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх тухай хууль болон олон улсын гэрээ, хориг арга хэмжээнүүдийн шаардлагын дагуу харилцагч банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад харилцагчийг таньж мэдэх шинжилгээг хийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, тогтмол хяналт тавьж ажилласан.

Түүнчлэн гадаад сонирхогч талууд болох Deutsche Bank, U.S. International Development Finance Corporation (DFC) – АНУ-ын хөгжлийн агентлаг болон Ernst & Young - Эрнст энд Янг Монголия Аудит ХХК зэрэг байгууллагууд нь МИК групп компанид харилцагчийг таньж мэдэх шинжилгээг тогтмол хэрэгжүүлдэг ба шаардсан холбогдох баримт материалыг тухай бүр хүргүүлж хамтран ажилласан.

Тайлан бэлтгэсэн: ХНГ-ын захирал  /Б.Болортуяа/